


ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул:

Монгол орны хэмжээнд газрын тосны хайгуулын 10, уламжлалт бус газрын тосны хайгуулын 8, газрын тосны ашиглалтын 4 талбайд тус тус Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-ний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа үргэлжилж байна. Үүнээс гадна БХГ байгуулах шатанд 1, Газрын тос боловсруулах үйлдвэрийн 1, гэрээлэгчгүй нийт 19 талбай байна.

Зураг 1. БХГ-т талбайн мэдээлэл:



Уламжлалт бус газрын тос буюу нүүрсний давхаргын метан хийн хайгуулын хувьд өнөөгийн байдлаар үйлдвэрлэлийн ашигтай нөөц бүхий орд газар хараахан тогтоогдоогүй байгаа бөгөөд метан хийн хайгуулын Номгон IX, Богд IV, Онги V, Т1, Тавантолгой XXXIII, Гурвантэс XXXV, Төв XXXVI, Ачит XXXVII зэрэг нийт 8 талбайд 6 гэрээлэгч аж ахуйн нэгж БХГ-ний дагуу хайгуул, судалгааны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

Хоёр. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл:

Өнөөгийн байдлаар нүүрсний давхаргын метан хийн 6, шатдаг занарын 1, газрын тосны 4, нийт 11 эрлийн ажил гүйцэтгэх гэрээ хэрэгжиж байгаа бөгөөд 2024 онд нийт 9 талбайд эрлийн ажлын төлөвлөгөө, төсвийг баталсан.

Гурав. Хайгуулын талбайд хийгдсэн ажил, хөрөнгө оруулалт:

Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, судалгааны чиглэлээр 1993-2024 оны хооронд нийт 292.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн ба үүнээс:

- ✓ 2022 онд 18.5 сая ам.доллар;
- ✓ 2023 онд 27.7 сая ам.доллар;
- ✓ 2024 онд 23.1 сая ам.долларын хөрөнгө оруулалт тус тус хийгдсэн.

БХГ-ний дагуу хайгуулын талбайнуудад хүндийн хүчний судалгаа 1:200000 масштабаар 272890 км² талбайд, соронзон хайгуул 77630 км² талбайд, пассив сейсмийн судалгаа 210 физик цэгт, магнито-теллурын судалгаа 180 физик цэгт, 2 хэмжээст чичирхийллийн судалгаа 38,753.429 тууш км, үүнээс микросейсмийн 2 хэмжээст чичирхийллийн судалгаа 1552.2 тууш.км, 3 хэмжээст чичирхийллийн судалгаа 7021.5 км² талбайд, агаарын бүрэн хэмжээст градиометрийн судалгаа 21990 км тус тус хийж, газрын тосны хайгуул, үнэлгээ, олборлолтын 1778, метан хийн хайгуул, үнэлгээний 126 цооног тус тус өрөмдсөн.


Хоёр. Газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалт:

Газрын тосны ашиглалтын 4 талбайд:

- ✓ Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК;
- ✓ 1997 оны БХГ-т талбайд “Доншен Газрын тос (Монгол)” ХХК;
- ✓ Матад XX талбайд “Петроматад” ХХК тус тус газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагааг явуулж байна.

Монгол Улсын хэмжээнд 1998-2024 оны хооронд нийт 11.51 сая тонн газрын тос олборлож, 11.03 сая тонн газрын тос БНХАУ-д экспортолсон. Улсын төсөвт 2.7 их наяд төгрөг (1.1 тэрбум ам.доллар) төвлөрүүлсэн.

Зураг 2. Газрын тосны олборлолт, улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн



2025 онд нийт 4,248,850 баррель буюу 579,000 тонн газрын тос олборлож, улсын төсөвт 347.9 тэрбум төгрөг төвлөрүүлнэ. 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 1,848,292 баррель буюу 250,868 тонн газрын тос олборлож, 1,765,705 баррель буюу 240,029 тонн газрын тос БНХАУ-д экспортолсон. Олборлолтын гүйцэтгэл 43.50 хувь, экспортын гүйцэтгэл 41.56 хувьтай байна.

Газрын тосны хайгуулын ажлын үр дүнд Тосон-Уул (Тосон-Уул XIX талбай), Тамсагийн (Тамсаг XXI талбай), Зүүнбаян, Цагаан-Элс (БХГ-97 талбай), Цэн Тогоруу (Матад XX) ордуудын нөөцийг тогтоож, тус ордуудын нөөцийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн. Нийт баталгаат геологийн нөөц 333.79 сая тонн, үүнээс олборлох боломжтой буюу ашиглалтын нөөц 43.4 сая тонн байна.

ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ОЛГОЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ:

Зөвшөөрлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Газрын тосны тухай хуулиудад тус тус заасны дагуу газрын тос хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, сунгах тухай хүсэлтийг тусгай зөвшөөрөл шийдвэрлэлтийн license.mn цахим системээр дамжуулан хүлээн авч шийдвэрлэж байна.

Нэг. Газрын тос, уламжлалт бус газрын тос хайх тусгай зөвшөөрөл:

Бүрдүүлэх баримт бичиг:

Хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Бүтээгдэхүүн хуваах гэрээний хуулбар;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
- Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө;
- Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан мөнгөн хөрөнгийг байршуулсан баримт.

Төрийн захиргааны төв байгууллага Газрын тосны тухай хуулийн 18.1, 18.2-т заасан баримт бичгийг хянан үзэж, хайгуулын тусгай зөвшөөрлийг хайгуулын хугацаагаар дараах этгээдэд олгож, сунгана:

- Эрлийн ажлын үр дүнд бүтээгдэхүүн хуваах гэрээ шууд байгуулсан;
- Энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан.

Газрын тосны хайгуулын хугацаа найм хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага хоёр хүртэл жилээр хоёр удаа, уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно. Бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан өдрөөс хайгуулын хугацааг тооцно.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болох бөгөөд энэ тохиолдолд гэрээлэгч доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад хугацаа сунгах хүсэлт ирүүлнэ. Үүнд:

- Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;
- Сунгасан хугацаанд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.

Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 18.9-д заасан баримт бичгийг хянаж хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл энэ хуульд заасан хугацаагаар сунгана.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10.в-д заасны дагуу газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 сая төгрөг, 25.1.10.г-д заасны дагуу эрэл хайгуулын хугацаа сунгахад жилд 4 сая төгрөг тушаана.

Хоёр. Газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл:

Бүрдүүлэх баримт бичиг:

Газрын тосны нөөцийг хүлээн авах тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч

ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлтийг Газрын тосны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу гаргана.

Үүнд:

- Газрын тосны нөөц бүртгэсэн тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;
- Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл;
- Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Ашиглалтын үеийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;
- Эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын байр зүйн зураг дээр ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг градус, секундээр тодорхойлж тэмдэглэсэн зураг;
- Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан мөнгөн хөрөнгийг байршуулсан баримт.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тохиолдолд гэрээлэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлт, үндэслэл;
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;
- Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10.д-д заасны дагуу орд ашиглах хугацаа сунгахад тус бүр 5 сая төгрөг тушаана.